



# Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт (ЖМТ) Гарын авлага ба жишиг бий болгох туршилтын төсөл

Мишэл Филион, MERIT төслийн Техникийн зөвлөх  
Имэйл: [michel1filion@hotmail.com](mailto:michel1filion@hotmail.com)

---

## ҮНДЭСЛЭЛ (1)

- Төрийн бодлого, тэр дундаа төсвийн санхүүжилтэд жендэрийн дүн шинжилгээ хийж хэвших талаар Бээжинд хотноо 1995 онд зохион байгуулсан Дэлхийн эмэгтэйчүүдийн IV бага хурлын үеэр яригдсан.
- ЖЭТБХ тухай хуулийн 19-р зүйлд зааснаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын чиг үүрэгт нь жендэрийн мэдрэмжтэй болгох арга зүйг нэвтрүүлэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийх явдал багтах болсон.
- Мөн хуулийн 5.1.4.-т хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөлд жендэрийн үзэл баримтлалыг тусгах, 16.1.1-т жендэрийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлтийн тогтолцоог нэвтрүүлэхийг тус тус үүрэг болгосон.
- ...

---

## ҮНДЭСЛЭЛ (2)

- ...
- Жендэрийн үндэсний хороо (ЖҮХ) нь Монгол Улсад ЖМТ-ийн зохих арга, аргачлалыг гаргахын тулд ажиллаж байгаа бөгөөд төсөвлөлтийн сайн практик нэвтрүүлэхийн тулд Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Хүн амын сан, Дэлхийн Банк (ДБ), Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (ГОУХАН), MERIT зэрэг олон улсын байгууллага, хандивлагчид, тэдний хэрэгжүүлж буй төслүүдтэй хамтран ажиллаж байна.
- Төсөв, санхүүгийн удирдлагын шинэчлэл хийх ажил ид өрнөж буй нь ЖМТ-ийг нэвтрүүлэх сайхан боломж бүрдүүлсэн юм.
- Хандивлагчдын энэ чиглэлээр ажиллах сонирхол ч өсөн нэмэгдэж байна.

---

## МОНГОЛ УЛС ДАХЬ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

- Нийт эрэгтэйчүүдийн 60 хувь, эмэгтэйчүүдийн 33 хувь нь сууцаа өөрсдөө өмчилдөг. Эрэгтэйчүүдийн 32 хувь, эмэгтэйчүүдийн дөнгөж 17 хувь нь малаа өөрийн нэр дээр өмчилдөг. (АХБ 2018)
- Эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо нь 67 хувь бол эмэгтэйчүүдийнх 53 хувь байна.
- Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо нь хүүхэд гаргаж өсгөх шалтгаанаар 3-9 жил тасалдаж байгаа бөгөөд Монгол Улсын “шимтгэл төлж ажилласан жилээр тэтгэвэр тогтоодог тэтгэврийн тогтолцоо” нь эмэгтэйчүүдэд сөргөөр нөлөөлж байж болзошгүй. (2016);
- Монгол эмэгтэйчүүдийн 30 хувь нь амьдралдаа бэлгийн буюу бие махбодын хүчирхийлэлд өртсөн байдаг (НҮБХАС, 2017).


---

## ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨСӨВЛӨЛТИЙН ТОДОРХОЙЛОЛТ (1)

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт гэж төсвийн эмэгтэй, эрэгтэй хүмүүс, охид хөвгүүдэд үзүүлэх ялгаатай нөлөөлөлд дүн шинжилгээ хийж, төсвийн баримт бичиг, үйл явцад жендэрийн үзэл баримтлалыг системтэйгээр нэвтрүүлэхийг хэлнэ. Ингэснээр алсуураа жендэрийн тэгш байдлыг хангах бодлогын зорилтдоо хүрэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой байдаг.

## ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨСӨВЛӨЛТИЙН ТОДОРХОЙЛОЛТ (2)

- Олон хүний бодлогоос эсрэгээр аливаа төсөв санхүүгийн бодлого нь жендэрийн хувьд “төвийг сахисан” байх албагүй хэмээх ажиглалтад тулгуурлан энэхүү арга хандлагыг боловсруулсан.



---

## MERIT ТӨСЛИЙН АРГА ХАНДЛАГА

- Бид төслийнхөө цар хүрээг харгалзан үзэж, орон нутгийн төрийн байгууллагуудын бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаанд хийх “хүйсээр ангилсан төсвийн зарлагын нөлөөллийн дүн шинжилгээ”-нд голлон төвлөрөх болно.
- Энэ бол микро бодлогын арга хандлага юм.

## ЭНЭ ТАЛБАР ДАХЬ ШИНЭ ЭХ СУРВАЛЖ: МОНГОЛ ГАРЫН АВЛАГА

Монголын онцлогийг тусгасан Орон нутгийн түвшинд жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг хийхэд зориулсан гарын авлагыг 2020 оны 7-р сард боловсруулж, хянан сайжруулж, хэвлэн гаргав.

Энэхүү гарын авлагыг MERIT төслийн жишиг бий болгох туршилтын төслийн оролцогчдын сургахад ашигласан бөгөөд сонирхсон бусад талууд, төрийн албан хаагчид, ард иргэд чөлөөтэй авч үзэх боломжтой.

Гол зорилго нь аймаг, орон нутгийн түвшинд төсвийн үйл явцад жендэрийн дүн шинжилгээг нэвтрүүлэхэд хэрэглэгдэх нэр томъёо, аргачлал, анхаарууштай болон амжилтын хүчин зүйлсийг тодорхойлж, таниулахад оршино.



---

## МОНГОЛЫН ОНЦЛОГТ ТОХИРУУЛАН ӨӨРЧЛӨХ АЖИЛ



Номыг Монголын онцлогт тохируулах ажлыг тухайн үед Монголд ажиллаж байсан мэргэжлийн баг гүйцэтгэсэн.


Гарын авлагад Монгол Улсын төсвийн мөчлөг, цаглабар, төрийн байгуулалт, соёлын онцлогийг харгалзан үзсэн.

2019 онд боловсруулсан Монголын кейс, жишээнүүдийг эх сурвалж болгон оруулсан.

## ҮР ШИМ ХҮРТЭГЧДИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ БУЮУ ЖЕНДЭРИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АЛХМУУД

- Судалж буй бодлого, хөтөлбөр, байгууллагын цар хүрээг тодорхойлох хүснэгт
- Төсвийн зарлагын эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, охид, хөвгүүдэд үзүүлэх нөлөөллийг шинжлэх хүснэгт
- Цалингийн зардлын эрэгтэй, эмэгтэй хүмүүст үзүүлэх нөлөөллийг шинжлэх хүснэгт
- Зөрүүтэй байдлын шалтгааныг тодорхойлж шинжлэх арга
- Тэгш байдлыг тогтооход чиглэсэн тусгай арга хэмжээ боловсруулах маягт.

## АЖЛЫН ЯВЦ



---

## ЖИШИГ БИЙ БОЛГОХ ТУРШИЛТЫН ТӨСЛИЙН ЗОРИЛТУУД

- Орон нутгийн төрийн байгууллага, төрийн албан хаагчдын хийсэн баг, сум, аймгийн түвшний хүйсээр ангилсан төсвийн зарлагын нөлөөллийн дүн шинжилгээний мөрөөрх хэрэгжилтийг үнэлж шалгах;
- Богино хугацаанд хэрэгжих “тэгш байдлыг тогтооход чиглэсэн тусгай арга хэмжээ”-г боловсруулж, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх;
- Хэрэгжилтэд тулгарах хүндрэл бэрхшээлийг шинжилж, орон нутгийн төрийн байгууллага, албан хаагчдын боловсруулж хэрэгжүүлж буйтай адил “шийдэл гаргалгаа” санал болгох;
- Ирэх 2 жилийн хугацаанд энэхүү туршилтын төслөө нэмэлт 3 аймагт түгээн дэлгэрүүлэх төлөвлөгөөний санал боловсруулах зэрэг болно.

## ТУРШИЛТЫН ТӨСЛИЙН ҮР ШИМ ХҮРТЭГЧИД

- Туршилтын төслийн үр шим хүртэгчид нь Дорнод аймгийн ЗДТГ, агентлаг, уул уурхай бүхий 5 сумдын төрийн албан хаагчид юм.

Сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдын тоо	70
Боловсруулсан тэгш байдлыг тогтооход чиглэсэн тусгай арга хэмжээний тоо	35
Хэрэгжсэн тэгш байдлыг тогтооход чиглэсэн тусгай арга хэмжээний тоо	20

---

## ГАЗАР ДЭЭР ГАРАХ ҮР НӨЛӨӨ

- Илүү олон үйлчилгээ эмэгтэй, эрэгтэй хүмүүст хүртээмжтэй болно.
- ЖМТ сэдвээр сургасан төрийн албан хаагчид бий болно.
- Төрийн албан хаагчид өөрийн бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаандаа хүйсээр ангилсан төсвийн зарлагын нөлөөллийн дүн шинжилгээ биечлэн хийх буюу хийхэд гар бие оролцоно.
- Бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаандаа хүйсээр ангилсан дүн шинжилгээ (үр шим хүртэгч, цалинжигчаар) хийнэ.
- Энэхүү дүн шинжилгээний дараагаар тэгш байдлыг тогтооход чиглэсэн тусгай арга хэмжээг санал болгоно.
- Тэгш байдлыг тогтооход чиглэсэн тусгай арга хэмжээг тусгахын тулд бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаанд зохих өөрчлөлт оруулна.

---

## ГОЛ ҮЙЛ АЖИЛЛАГАА (1)

- Баг, сум, аймгийн түвшний төрийн албан хаагчдад ЖМТ-ийн чадавх бүрдүүлэх сургалт орох (хөтөлбөр төлөвлөлт, ЖМТ болон хүртээмжтэй бодлогын сэдвээр);
- Эдгээр албан хаагчдад тэгш байдлыг тогтооход чиглэсэн тусгай арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэхэд нь менторшип, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх;
- Төрийн албан хаагчдад ЖМТ-ийн мэдлэг ойлголт бататгах семинар орох;
- Тэгш байдлыг тогтооход чиглэсэн тусгай арга хэмжээгээ сурталчилж, таниулахад нь зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх
- ...


---

## ГОЛ ҮЙЛ АЖИЛЛАГАА (2)

- ...
- Төслийн менежментийн чадавх бэхжүүлэх сургалт семинар;
- ХШҮ-ний чадавх бэхжүүлэх сургалт семинар;
- Асуудал, маргаан шийдвэрлах сэдэвт менторшип хийх.

## АНХДАГЧ ҮР ДҮН

- 75 хүн сургалтад хамрагдсан.
- 35 тэгш байдлыг тогтооход чиглэсэн тусгай арга хэмжээ боловсруулсан.
- 9 удаагийн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.
- Тэгш байдлыг тогтооход чиглэсэн тусгай арга хэмжээний 50 хувь нь хэрэгжилт сайтай байна.





Монгол Улс: Институцийн өөрчлөлт  
хийх замаар эрдэс баялгийн  
менежментийг сайжруулах нь

**Хаяг:** Нэйшнл таймс ньус тауэр, 3-р давхар  
Худалдааны гудамж, Хороо 1  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар-15160

**Утас:** 7610-5000